

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

2020 оны жилийн эцэс

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1.3.1. Боловсролыг хөгжүүлэх бодлого, стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, мэргэжлийн холбоо, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, иргэний оролцоог хангах						
1	1. Бага боловсролыг эх хэлний чадамжийг эзэмших боломжийг бүрдүүлэн бүтээлч, сурах арга барилтай Монгол хүүхэд төлөвших үе хэмээн хөгжүүлнэ. Суурь боловсролыг амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар,	2014 - 2024			Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 2019 оны А/491 дүгээр тушаалаар бага, дунд, ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг шинэчлэн баталлаа. Шинэчлэн баталсан бага ангийн сургалтын төлөвлөгөөний дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Хөтөлбөр батлах тухай” 2019 оны А/492 дугаар тушаалаар бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулан боловсруулж, баталсан. 1-5 дугаар ангийн сайжруулсан сургалтын хөтөлбөрийг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын нийт сургуулиудад хэрэгжүүллээ. Сайжруулсан монгол хэлний сургалтын хөтөлбөрөөр сурагчид 1-3 дугаар ангид 14, 4-5 дугаар ангид 18 унших, бичих, сонсох, ярих чадвар, тус тус 4 хэлзүй, үгийн сангийн чадвар эзэмших бөгөөд 1-3-р ангид нийт 90, 4-5 дугаар ангид 61 зүйлийн агуулга судалж байна. Дунд ангийн сургалтын төлөвлөгөөний дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Хөтөлбөр батлах тухай” 2019 оны А/492 дугаар тушаалаар суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулан боловсруулж, баталлаа. 6-9 дүгээр ангийн сайжруулсан сургалтын хөтөлбөрийг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын нийт сургуулиудад хэрэгжүүллээ. Суурь боловсролын нийт сургалтын хөтөлбөрийг шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадамж эзэмшихэд тулгуурлан сайжруулан боловсрууллаа. Ахлах ангийн сургалтын төлөвлөгөөний	100%

	бие даан бүтээлчээр суралцах чадамж эзэмших үе хэмээн хөгжүүлнэ. Бүрэн дунд боловсролыг сонголттой уян хатан хөтөлбөрөөр мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь баримжаа олгох үе хэмээн хөгжүүлнэ.			дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Хөтөлбөр батлах тухай” 2019 оны А/492 дугаар тушаалаар суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулан боловсруулж, баталлаа. 10-12 дүгээр ангийн сайжруулсан сургалтын хөтөлбөрийг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын нийт сургуулиудад хэрэгжүүллээ. Ахлах ангид сурагчид сонирхол хэрэгцээ, ирээдүйд эзэмших мэргэжлийн сонголтод суурилсан, уян хатан сургалтын зохион байгуулалттай болж, хичээл сонгох боломжийг өргөжүүллээ.	
2	2. Насан туршийн боловсролын үйлчилгээний төрөл, хэлбэр, сургалтын байгууллагыг өргөжүүлэн бэхжүүлнэ.	2014 - 2024		Албан ёсны сургалтад хамрагдаж чадаагүй, чадахгүй нөхцөлд байгаа суралцагчдыг мэдээллийн технологид суурилсан танхимын, гэрийн, онлайн хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулж байна. “Дүйцсэн сургалтын хөтөлбөрийг мэдээллийн технологид суурилан шинэчлэх үзэл баримтлал, дизайнчлал”-ын хүрээнд ерөнхий боловсролын сургалтын 17 хичээлд тулгуурлан бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд 48 судлагдахуунаар хөтөлбөр боловсруулах, ажлыг 2020 оны 7 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд хийж гүйцэтгэлээ.	90%
3	3. Боловсролын хөгжлийн стратегийг	2014 - 2024		Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын албанаас “Магадлан итгэмжлэлд мэргэжлийн зөвлөлийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийг 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт	70%

<p>тодорхойлох, нийтлэг зохицуулалт хийхэд зөвлөх эрх бүхий мэргэжлийн гишүүдээс бүрдсэн боловсролын зөвлөлийг байгуулж, тогтвортой ажиллуулна</p>			<p>Боловсрол, Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалал, Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлийн 30 орчим гишүүд оролцож магадлан итгэмжлэлийн өнөөгийн байдал, мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаанд орчин үеийн болон олон улсын чиг хандлагыг тусгах чиглэлээр санал бодлоо солилцсон</p>	
<p>4. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, шинжлэх ухаан, технологийн дэвшил, иргэдийн сурах хэрэгцээ, ажлын байранд тавих шаардлагатай уялдуулан тасралтгүй хөгжүүлнэ.</p>	<p>2014 - 2024</p>		<p>Үр дүнд суурилсан боловсролын бодлогын 4.1.6-д заасны дагуу дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн боловсруулалтад үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн А/405 дугаар тушаалаар байгуулан 60 гаруй их, дээд сургуулийн 536 бакалаврын хөтөлбөрт үнэлгээ хийж, чиглэл, зөвлөмжийг холбогдох их, дээд сургуулиудад өгсөн. Хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хийж төгсөгчдийн мэдлэг, чадварыг ажил олгогчдын эрэлтэд нийцүүлнэ. Сэтгэ-Зохио-Бүтээ-Хэрэглэ (CDIO: Conceive-Design-Implement-Operate) арга зүйгээр технологийн хөгжлийн эрин зуунд мэргэжлийн өндөр ур чадвартай, нийгмийн хариуцлагатай, бүтээлч сэтгэлгээтэй инженерийг бэлтгэдэг арга зүйг нэвтрүүлснээр сургалтын хөтөлбөрийн агуулга, заах арга, үнэлгээ сайжирч олон улсын инженерийн боловсролын түвшинд ойртож, төгсөж буй оюутны чадамж ажлын байрны хэрэгцээтэй нийцэж байгаа болно. Ажлын хэсгийн 9 багийн тайланд хөтөлбөрийн ерөнхий 10 чиглэлээр дүн шинжилгээ хийн гарсан үр дүнг 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан “CDIO-2019” эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлсэн. МУИС-ийн Хэрэглээний математикийн тэнхимийн Ус судлалын хөтөлбөрийн магистрант, Хүрээлэн буй орчны инженерчлэлийн лабораторийн судлаач оюутан М.Энх-Үүр 2020 оны 1 дүгээр сард олон улсын эрдэм шинжилгээний “Water” сэтгүүлд 1-р зохиогчоор “Application of the City Blueprint Approach in Landlocked Asian Countries: A Case Study of Ulaanbaatar, Mongolia” сэдэвт өгүүлэл хэвлүүлжээ. Уг сэтгүүлийг Швейцар Улсын MDPI хэвлэлийн газраас эрхлэн гаргадаг, Web of Science болон Scopus-д</p>	<p>100%</p>

				бүртгэлтэй, 2.5 импакт фактортой, усны салбартаа 1-р эрэмбийн (Q1) сэтгүүл юм. Судалгааны ажлын хүрээнд УЦУОШГ-ийн Усны сектор, Ус сувгийн удирдах газар, БОАЖЯ-ны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар, Сав газрын удирдлагын хэлтэс гэх мэт усны асуудал хариуцсан үндэсний олон байгууллагатай хамтран ажилладаг.	
1.3.2. Боловсролын талаар шийдвэр гаргах үйл явц нь нээлттэй, ил тод, судалгаа, нотолгоонд суурилсан, сайн засаглалын зарчимд нийцсэн байх					
5	1. Сургуулийн өмнөх боловсролын стандарт, цөм хөтөлбөрийг төрөөс тогтоож, чанар, үр дүнг үнэлнэ.	2014 - 2024		“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” /2014-2024/-ын энэхүү зорилт нь бага насны хүүхдийн хөгжил суралцахуйн онол арга зүй, сургуулийн өмнөх боловсрол эзэмших орчин үед бий болсон хувьсал өөрчлөлтөд нийцүүлэн өөрчлөх шаардлага тулгарч байна. Үүнтэй уялдуулан сургуулийн өмнөх боловсролын зорилгыг Боловсролын тухай хууль, сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгад өөрчлөн тусгасан. Бага насны суурь чадвар нь насан туршдаа суралцахуйн үндэс болохыг Боловсролын ерөнхий хуулийн зорилтод тусгаж, хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийг хангахыг сургуулийн өмнөх бага дунд боловсролын хуулийн зорилгод тусгаж төсөл боловсруулсан.	90%
6	2. Боловсролын үйл хэргийг удирдахад төрийн болон орон нутгийн захиргааны, иргэний нийгмийн байгууллага, гэр бүл, нийгмийн бүх салбарын оролцоонд суурилсан хамтын ажиллагааг бэхжүүлнэ.	2014 - 2024		Боловсролын сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх үйл ажиллагаанд төрийн болон нутгийн захиргааны, иргэний нийгмийн байгууллага, эцэг эх асран хамгаалагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэхэд Боловсролын салбарт хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичгүүдэд тусган хэрэгжилтийг хангаж байна. Үүнд: БСШУ-ны сайдын 2019 оны А/803 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам”-д суралцагч, эцэг эх, асран хамгаалагчаас мэдээлэл цуглуулах, үнэлгээний багт суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийг оруулах, үнэлгээний үр дүнг тухайн цэцэрлэг, сургуулийн хамт олон, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулах бөгөөд хөндлөнгийн үнэлгээний үр дүнг сум, дүүргийн Засаг даргад танилцуулахаар зохицуулсан. БШУ-ны сайдын 2020 оны А/164 дүгээр тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх боловсролын сургалт үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийн 7 дугаар заалтад “Эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагааг хангах талаар дараах асуудлыг тусган хэрэгжүүлж байна. Хүүхдийн хөгжил, төлөвшилд эцэг эх, асран хамгаалагчийн эерэг үлгэр дуурайллыг бий болгоход чиглэсэн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх Эцэг эх, асран хамгаалагчдад сургалт, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, хүүхдийн хөгжлийг дэмжих асуудлаар	100%

				зөвлөлдөх, , шийдвэр гаргах, хяналт тавихад оролцоог хангах; Сургалт үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагчдад нээлттэй танилцуулж, хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих, танхимын сургалтаар эзэмшсэн мэдлэг, чадвар, дадал, хэвшлийг бататгахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд тэдний оролцоог нэмэгдүүлэхэд чиглүүлэх; Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн аюулгүй байдлыг хангах, осол аюул, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд тулгарч буй бэрхшээл, эрэлт хэрэгцээг судлан шийдвэрлэх, зөвлөгөө, мэдээлэл тогтмол өгдөг байх; Багш, ажилтан нь хүүхдийн гэр бүлийн соёл, уламжлал, зан заншил, ялгаатай байдлыг хүндэтгэн харилцдаг байх зэрэг юм	
7	4. Боловсролын байгууллагад өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш шаардлага тавьж, хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.	2014 - 2024		2020 онд боловсруулж батлуулсан дараах эрх зүйн баримт бичгүүдийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мөрдөж хэрэгжүүлэхээр заасан. Үүнд: - Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлэх журам /БСШУС-ын сайдын 2019 оны А/803 дугаар тушаал/- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил, сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний журам /БШУ-ны сайдын 2020 оны А/280 дугаар тушаал/- Сургуулийн өмнөх боловсролын сургалт үйл ажиллагаанд баримтлах чиглэл /БШУ-ны сайдын 2020 оны А/164 дүгээр тушаал/- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт, үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай /БСШУС-ын сайдын 2020 оны А/194 дүгээр тушаал/- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээний төлөвлөгөө /БСШУС-ын сайдын 2020 оны А/194 дүгээр тушаал/ тус тус байна.	100%
8	5. Боловсролын байгууллагын хараат бус, бие даасан байдал, дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагын академик эрх чөлөөг хангана.	2014 - 2024		ШУТИС-ийн Бүрэлдэхүүн сургуулиуд 2020 онд эрдэм шинжилгээ, туршилт судалгаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд гадаад, дотоодын байгууллагуудтай 12 гэрээ, санамж бичгүүдийг байгуулан ажиллаж байна. 2020 онд төслийн хэрэгжилтийн хүрээнд АНУ-ын Массачусетсийн Технологийн их сургуулийн J-WEL боловсролын төвтэй хамтран дараах ажлуудыг хамтран зохион байгууллаа. Үүнд: -“MIT J-WEL CONNECTION - 2020” онлайн арга хэмжээ “Reimagining Curriculum” сэдвийн хүрээнд 2020.03.30-2020.04.10-ны хооронд зохион байгуулагдсан бөгөөд ШУТИС-иас 18 профессор, багш оролцсон. Үүнд Инженерийн дээд боловсролын хөгжлийн чиг хандлага (Next Engineering Education Transformation - NEET), сургах, суралцахуйн шинэ арга зүй, технологи, онлайн сургалтын талаарх шинэ мэдээлэл авч, туршлага судалсан. -J-WEL-Workshop:	100%

				<p>“Remotely Designing for Learning: From Principles to Practice” сэдвийн хүрээнд 2020.07.13-08.14-ний хугацаанд зохион байгуулагдахад ШУТИС-иас 4 багш оролцсон. Сургалтын үр дүнд олж авсан шинэ мэдлэг, мэдээллийг ашиглан 2020.08.20-оос 2020.11.10-ны хооронд ШУТИС-ийн бүрэлдэхүүн 8 сургуулийн нийт 30 гаруй профессор, багш нарт Онлайн сургалтын орчин үеийн чиг хандлага, онцлогийн талаар цуврал сургалтуудыг зохион байгуулсан. -J-WEL-Connection: “Activating the Ecosystem to Reimagine Education” сэдвийн хүрээнд 2020.10.05-2020.11.29-нд зохион байгуулагдсан хуралд ШУТИС-ээс 6 багш оролцсон. Цар тахлын улмаас Дээд боловсролын хөгжлийн чиг хандлага хэрхэн өөрчлөгдөж байгаа болон онлайн, танхимын сургалтыг хэрхэн үр дүнтэй зохион байгуулж явуулах, түнийг хэрхэн зөв үнэлэх, дүгнэх талаар харилцан туршлага судалсан. -J-WEL-Workshop: “Success Factors in University and Industry Collaboration” сэдвийн хүрээнд 2020.11.17-2020.12.8-ны хооронд зохион байгуулагдахад ШУТИС-иас 2 багш оролцсон. Их дээд сургууль, аж үйлдвэрийн салбарын үр дүнтэй хамтын ажиллагаа хэрхэн зохион байгуулан явуулж буй дэлхийн тэргүүлэх их сургуулиудын туршлагыг ШУТИС-д нэвтрүүлэх боломж бүрдсэн байна.</p>	
9	6. Дэлхийн болон олон улсын боловсролын төрөлжсөн байгууллагад гишүүнээр элсэх, салбар, нэгж байгуулах, конвенцид нэгдэн орохыг дэмжинэ.	2014 - 2024		<p>Монгол улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 399 дүгээр тогтоолоор “Дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай Ази, Номхон далайн бүс нутгийн 2011 оны Токиогийн конвенц”-д нэгдэх шийдвэр гаргасныг ЮНЕСКО батламжилсан юм. Ийнхүү конвенц нь Монгол улсад 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Ингэснээр Ази, Номхон далайн орнууд, тэр дундаа Япон, Австрали, Шинэ Зеланд, БНСУ зэрэг өндөр хөгжилтэй оронд Монгол улсын дээд боловсролын сургалтын хөтөлбөр, диплом, эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөхөөс гадна тухайн улсад мэргэжил дээшлүүлэх, үргэлжлэн суралцах, эрдмийн зэрэг хамгаалах, ажил хөдөлмөр эрхлэх, шилжилт хөдөлгөөнд эерэг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдсэн юм. МУБИС нь Монгол Улсын болон БНХАУ-ын их сургуулиудын холбоо, Зүүн Өмнөд Азийн багш боловсролын сүлжээ болох АsTEN-д гишүүнээр элсэж, онлайн хурал, сургалтад мэргэжлийн багш нар, оюутнуудыг оролцуулж байна.</p>	100%
10	7. Иргэдийн насан туршийн боловсрол эзэмших үйл хэргийг	2014 - 2024		<p>Гадаад дахь монгол хүүхдийн эх хэл, соёлын хичээлийг зохион байгуулж буй багш нарт цахим хичээл боловсруулах, цахим сургалт зохион байгуулах болон хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээг цахим хэлбэрээр хэрхэн зохион байгуулах талаар мэргэжил, арга зүйн дэмжлэгийг үзүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд Боловсролын хүрээлэн, Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл, Багшийн</p>	70%

	хөгжүүлэхэд төр, дотоод, гадаадын олон нийт, мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, хувь нэмрийг хөхүүлэн дэмжиж, түншлэлийг өргөжүүлэн хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлнэ.			мэргэжил дээшлүүлэх институт, Насан туршийн боловсролын үндэсний төв хамтран хоёр дахь цахим сургалтыг 2020 оны 12 сарын 03-19-ны өдрүүдийн хооронд зохион байгуулсан. Сургалтын онцлог нь багш нарыг анхан ба ахисан хоёр түвшинд, мөн Америк Канад-Ази Европ гэсэн хоёр бүсэд хувааж, судлах хичээлийн агуулгыг “Цахим сургалтын технологи”, “Монгол хэлний жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх аргачлал”, “Даалгавар боловсруулах арга зүй” гэсэн 3 бүлэг сэдвийн хүрээнд судалсан.	
11	8. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад өөрийн үнэлгээ, дотоод мониторингийн тогтолцоог хөгжүүлнэ.	2014 - 2024		Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/803 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам” батлагдсан. Энэхүү журмаар боловсролын байгууллагын өөрийн үнэлгээ, дотоод мониторинг хийх тогтолцоог бүрдүүлсэн. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг үнэлэхэд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний хэлбэрийг ашиглах бөгөөд өөрийн үнэлгээг тухайн цэцэрлэг, сургууль, хөндлөнгийн үнэлгээг аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газар тус тус хариуцан зохион байгуулахаар заасан. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг үнэлэх үнэлгээ нь байгууллага дэвшүүлсэн үнэт зүйл, эрхэм зорилго, зорилтдоо хүрч буй эсэхээ багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой үнэлж, байгууллагын менежмент, сургах, сурах үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулахад нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээ тодорхойлон түүний хэрэгжилтийг давтамжтайгаар үнэлдэг эргэх холбоо бүхий үйл явц байхаар зохицуулсан.	100%
12	9. Дээд боловсролын чанарын	2014 - 2024		Монгол Улсын их, дээд сургуулиудын судалгаа, инновацийн чадавхыг хөгжүүлэх зорилготой “ЕХ-ны Ерасмус+” хөтөлбөрөөс санхүүжиж буй “ARROW” (Improvement of Research and Innovation skills in Mongolian Universities) төсөл 2018 оноос эхлэн	100%

<p>баталгаажилт, магадлан итгэмжлэлийн тогтолцоог төгөлдөржүүлнэ.</p>			<p>хэрэгжиж эхэлсэн. Тус төслийн хэрэгжилтийн хүрээнд зохион байгуулсан “Univerisity Knowledge Transfer” цахим сургалт 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 3 дугаар сарын 17-ны өдрүүдийн хооронд цахимаар амжилттай болж өндөрлөсөн. Тус сургалтад 12 их, дээд сургуулийн 180 орчим багш, судлаач, мэргэжилтэн амжилттай суралцлаа. АХБ-ны Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл ба Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын олон улсын сүлжээ (INQAАНЕ) хамтран “Чанарын дотоод баталгаажуулалт” сэдэвт цахим сургалтыг 2020 оны 5 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтанд төрийн өмчийн 11 их сургууль (МУИС, АШУУИС, МУБИС, ШУТИС, МГАМТИС, СУИС, ХААИС, Дорнод их сургууль, Ховд их сургууль, ДХИС, ҮБХИС), хувийн өмчийн 14 их, дээд сургуулиас (Хүмүүнлэгийн их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Технологи, технологийн дээд сургууль, Их засаг олон улсын их сургууль, Олон улсын Улаанбаатарын их сургууль, Сан их сургууль, Шихихутуг их сургууль, Эм Ай Ю дээд сургууль, Билиг дээд сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль, Сэрүүлэг дээд сургууль, Шинэ иргэншил дээд сургууль, Энэрэл дээд сургууль, Маргад дээд сургууль)-ийн 300 багшийг онлайн оролцуулан зохион байгуулсан. Сургалтаар “Сургуулийн эрдэм шинжилгээ, судалгаанд чанарын дотоод баталгаажуулалтыг хангах нь” сэдэвт лекц, Тайван, Оросын Холбооны Улс болон Монгол Улсын МУИС болон Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн дотоод баталгаажуулалтын арга зүй, туршлагатай тус тус танилцсан</p>	
<p>13 10. Боловсролын мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургаж бэлтгэх, дадлагуулах, тогтвор суурьшилтай ажиллах</p>	<p>2014 - 2024</p>		<p>1.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/09 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэдэг их дээд сургуулиудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх зорилгоор БСШУС-ын сайдын 2020 оны А/61 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдан 24 сургуулийн хөтөлбөрт Боловсролын хүрээлэнтэй хамтран шинжилгээ хийж дүгнэлт гаргалаа. Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын сайдын “Сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/279 дүгээр тушаал батлагдаж “Багш сургуулийн өмнөх насны боловсрол” хөтөлбөрөөр багш бэлтгэх сургуулиудын хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, багшийн чанарыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авах, дээд боловсролын сургалтын байгууллагуудад зөвлөгөө дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг чиглэл өгсөн бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2. Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь</p>	<p>100%</p>

	нөхцөлийг бүрдүүлнэ.			заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/61 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор БСШУС-ын сайдын “Сургалтын жишиг хөтөлбөр батлах тухай” 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/278 дүгээр тушаалаар цэцэрлэгийн туслах багшийг багш бэлтгэх их дээд сургуулийн сургалтаар бэлтгэх жишиг хөтөлбөрийг баталсан. Энэхүү жишиг хөтөлбөрийг цэцэрлэгийн туслах багшийн хэрэгцээ, шаардлага, туслах багшийн албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрлөх харилцаатай холбоотой эрх зүйн баримт бичиг, хуулиар хүлээх үүрэг хариуцлага, шинэ зууны сургуулийн өмнөх боловсролын байгууллагын менежмент, хүний нөөцийн шаардлагатай ур чадвар зэрэгт үндэслэж боловсруулсан.	
1.3.3. Боловсролын байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бүтэц, байршил, онцлог хэв шинжид уялдуулан уян хатан тогтоож байх					
14	1. Ерөнхий боловсрол нь 12 жилийн тогтолцоотой байх бөгөөд ерөнхий боловсрол эзэмших тасралтгүй, залгамж чанарыг хангаж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шатлал бүтцийг баримтална.	2014 - 2024		Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан болон албан бус боловсролын нэгдэл бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрдэхээр хуульчлан хэрэгжүүлж байна. 1. Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт бага, дунд боловсрол эзэмшүүлэх хугацааг 12 жил буюу 5+4+3 гэсэн бүтэцтэй байхаар хуульчилсан байдаг. ЮНЕСКО-гоос 2017 онд гаргасан дэлхийн улс орны боловсролын тогтолцооны албан ёсны статистикийн мэдээлэлд хамрагдсан нийт 222 орны 60.4 хувь нь 12 жилийн сургалтын тогтолцоотой бол 12 жилийн сургалтын тогтолцоотой орнуудын 15.7 хувь нь 5+4+3, 42.5 хувь нь 6+3+3 бүтэцтэй байх тул манай улсын хувьд сургалтын тогтолцоо, бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх хугацааны хувьд олон улсын жишигт байна гэж дүгнэж болохоор байна. Ерөнхий боловсролын сургуульд хэрэглэж байгаа I-XII ангийн бүх сурах бичгийг цахим хэлбэрээр www.econtent.edu.mn , www.meds.gov.mn веб хуудсанд байршуулж, хэрэглэгчдэд нээлттэй ашиглуулж байна. Мөн андройд, ios үйлдлийн системтэй төхөөрөмжөөр сурах бичгийг ашиглах аппликейшн бий болгосон. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид сурах бичгийг тохиромжтой хэлбэрээр ашиглах боломжийг бий болгох чиглэлээр холбогдох төрийн бус байгууллагуудыг дэмжин хамтран ажиллаж байна.	100%
15	2. Боловсролын байгууллагын орчинд суралцагчийг эрсдэлд	2014 - 2024		Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А/476 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”-ыг баталлаа. Энэхүү бодлого батлагдсанаар сургууль, дотуур байрын орчинд суралцагчдыг аливаа болзошгүй эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдээлэл, таамаглалыг хүлээн авах,	100%

<p>өртөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.</p>			<p>хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, хяналт үнэлгээний нэгдсэн тогтолцоо бий болж суралцагч бүрийн аюулгүй байдлыг хангах юм. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн С/40 дүгээр тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын орчин, үйлчилгээ MNS 6781:2019, Ерөнхий шаардлага” болон “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал MNS 6782:2019, Ерөнхий шаардлага” батлагдсан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Бодлогын баримт бичиг батлах тухай” 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/269 дүгээр тушаалаар “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого”-ын баримт бичгийг баталлаа. Тус бодлогын баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Монгол Улсын Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн боловсруулсан. Хүүхэд хамгааллын бодлого нь (I) үндэслэл, (II) зорилго, (III) хамрах хүрээ, (IV) хэрэгжүүлэх арга зам, (V) хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм гэсэн нийт 6 хэсгээс бүрдсэн. Тус баримт бичигт цэцэрлэг нь хүүхэд хамгааллын багтай байхаар төлөвлөсөн бөгөөд хүүхэд хамгааллын аливаа болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, шилжүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх холбон зуучлах ажлыг зохицуулан ажиллахаар тусгасан.</p>	
<p>16</p> <p>3. Их сургуулийг хотхоноор хөгжүүлэх бодлого гарч, хэрэгжиж эхэлсэн байх</p>	<p>2014 - 2024</p>		<p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/48 дугаар тушаалаар “Судалгаанд суурилсан үндэсний их сургуулийг хөгжүүлэх, их сургуулийн хотхоныг байгуулах ажлыг үе шаттай эхлүүлж, хяналт тавьж ажиллах” ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажилтай холбоотой дараах ажлууд хийгдсэн болно. Үүнд: 1.Багануур дүүрэгт “Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, технологийн цогцолбор”-ийг байгуулахаар төлөвлөн 2015 онд ТЭЗҮ, Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж дуусгасан. 2.Дархан-уул аймагт “... бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төв” хотхоны ажлыг 2021 онд эхлүүлэхээр төлөвлөн 5 яамны төлөөллийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулахаар яамдуудаас санал аван ажиллаж байна. 3.Дорнод аймагт “Зүүн бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төв”-ийг байгуулахаар ТЭЗҮ, Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2020 онд боловсруулж дууссан бөгөөд бүтээн байгуулалтыг 2021 оноос эхлүүлэхэд бэлэн болсон. 4.Ховд аймагт хотхон байгуулах газрыг шийдвэрлэн, инженер геологийн суурь судалгаа хийгдсэн.</p>	<p>100%</p>

				5.Орхон аймагт хотхон байгуулах газрыг шийдвэрлэн, инженер геологийн суурь судалгаа хийгдсэн. 6.Сэлэнгэ аймагт “Хөдөө аж ахуй, био технологийн их сургуулийн ТЭЗҮ, зураг төсөв” боловсруулах чиглэлээр 2021 оны төсөвт 1.2 тэрбум төгрөг	
1.3.4. Боловсролын удирдлагын бүх түвшинд төрийн болон орон нутгийн, мэргэжлийн олон нийтийн төлөөллийн байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагааны зааг, ялгаа, уялдаа холбоог тогтоож, эрх зүйн хувьд баталгаажуулах					
17	1. Боловсролын салбарт гарч байгаа бүтээлч санал, санаачилга, үйл ажиллагааг дэмжин, түгээн дэлгэрүүлнэ.	2014 - 2024		Их сургуулиудын онцлог, үнэт зүйл, уламжлал соёлыг эрхэмлэн, их сургуулиудын багш, оюутан, хүний нөөцийн хөгжлийн бодлого, эрдэм шинжилгээ судалгаа, сургалтын болон бусад үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах зорилгоор МУИС, ШУТИС, МУБИС, ХААИС, АШУҮИС-иуд хамтын ажиллагааны санамж бичгийг 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр байгуулж, гарын үсэг зурж баталгаажуулсан. Энэхүү санамж бичгийн хүрэнд төрийн өмчийн 5 их сургууль дээд боловсролын хөгжлийн бүхий л асуудлаар мэдээлэл, туршлагаа солилцож харилцан суралцах, хамтран ажиллах чиглэлийг тодорхойлж, төрийн өмчит их сургуулиуд хамтдаа хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэхээр тохиролцсон юм. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, “Оюу толгой”, “Эрдэнэс таван толгой”, Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийн хүний нөөц, мэргэжилтэн бэлтгэх, шинээр холбогдох мэргэжлийн хөтөлбөр боловсруулах талаар хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд 7 сургалтын хөтөлбөрийн 9 мэргэжил шинээр нээж, элсэлт авсан.	70%
18	2. Боловсролын салбарт жендерийн тэгш байдлыг хангах бодлого боловсруулж үе шаттай хэрэгжүүлнэ	2014 - 2024		МУБИС дээр "Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төсөл хэрэгжиж байгаа бөгөөд тус төслийн хүрээнд Боловсролын хүрээлэн, "Мэргэжлийн боловсрол сургалт түншлэл" ТББ, МУБИС "Жүжигчилсэн тоглолтоор дамжуулан Жендэрийн ойлголтыг түгээн дэлгэрүүлэх нь (ГАТТ)" сэдэвт сургалтыг 2020-11-10 нд МУБИС-ийн А200 танхимд зохион байгуулав. Тус сургалтад МУБИС, Боловсролын хүрээлэн, БМДИ, Боловсролын үнэлгээний төв, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Насан туршийн боловсролын төв, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Байгаль орчин мэдээлэл сургалтын төв зэрэг байгууллагуудын төлөөлөл болон бусад байгууллагын төлөөлөл 50 орчим хүн оролцсон.	90%
19	3. Боловсролын хөгжлийн стратегийг	2014 - 2024		Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын дэргэд Сургуулийн өмнөх, Бага дунд, Дээд боловсролын бодлогын зөвлөл байгуулан ажилласан. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын албанаас “Магадлан итгэмжлэлд	90%

<p>тодорхойлох, нийтлэг зохицуулалт хийхэд зөвлөх эрх бүхий мэргэжлийн гишүүдээс бүрдсэн боловсролын зөвлөлийг байгуулж ажиллуулна.</p>				<p>мэргэжлийн зөвлөлийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийг 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт Боловсрол, Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалал, Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлийн 30 орчим гишүүд оролцож магадлан итгэмжлэлийн өнөөгийн байдал, мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаанд орчин үеийн болон олон улсын чиг хандлагыг тусгах чиглэлээр санал бодлоо солилцсон.</p>	
<p>1.3.5. Боловсролын салбарын удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг өргөтгөх</p>					
<p>20</p> <p>1. Мэдээллийн системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх ажил хийнэ.Дата төвийн мэдээллийн системийн сервер тоног төхөөрөмжийг өргөтгөнө.</p>	<p>2014 - 2024</p>			<p>Дээд боловсролын удирдлага мэдээллийн системийг хөгжүүлэх төслийг амжилттай зохион байгуулснаар их дээд сургуульд элсэгчдийн болон дээд боловсролын сургалтын байгууллагын статистик мэдээллийн санг хөгжүүлэх ажил олон улсын жишигт хүрэхүйц болж өөрчлөгдсөн. Энэ ажлын хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллага, багш, ажилтан ажилчид болон оюутнуудын цогц мэдээлэл болон сургалтын хөтөлбөр, төгсөгчдийн мэдээлэл, хөдөлмөр эрхлэлтийг тодорхойлох бүрэн боломж бүрдсэн. Ийнхүү дээд боловсролын сургалтын байгууллагуудын үйл ажиллагаа элсэлт, төгсөлт, шилжилт хөдөлгөөний байдал, диплом олголт, бүртгэл мэдээллийн нэгдсэн нэг системд орж салбарын мэдээлэл иргэд олон нийтэд нээлттэй болох нөхцөл бүрдээд байна. “Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2015-2020 оны статистикийн мэдээллийн дүн шинжилгээ” судалгааны ажлын үр дүнгийн тайланг боловсруулж, хэвлүүлэн удирдлагуудад хүргүүлж, мэдээллээр хангасан. “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024” баримт бичигт салбарт мэдээлэл технологийн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний чиглэлийг боловсруулж тусгаж батлуулсан. Боловсролын салбарын цахим шилжилт үзэсгэлэн зохион байгуулсан. ТҮЦ машин болон E-Mongolia цахим системээр боловсролын баримт бичгийн 4 төрлийн лавлагааг олгож байна. 2021 оны 1 дүгээр улиралд багтаан боловсролын салбарын байгууллагад суралцаж буй эсэх 3 төрлийн лавлагааг олгодог болгохоор боловсролын салбарын системийн хөгжүүлэлт болон журмын төслийг</p>	<p>100%</p>

				<p>боловсруулан ажиллаж байна. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас олгож байгаа ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардагдах бүрдүүлэх материал холбогдох баримт бичгийг цахимаар хүлээн авч шийдвэрлэдэг болгох ажлыг 2021.01 сард багтаан эхлүүлэхээр ажиллаж байна. Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд Боловсролын үнэлгээний төв дээр сурагчдын чанарын үнэлгээ дээр суурилж багшийн үр өгөөжийг үнэлэх цахим програм хангамжийг боловсруулахаар ажиллаж байна.</p>	
--	--	--	--	--	--